



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот


Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай" 78 тоот зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны "Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай" 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам", Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны "Журам, чиглэл шинэчлэл батлах тухай" 71 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Журам батлах тухай" А/316 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2014 оны А/219 дугаар тушаалын Лхагважав овогтой Энхтөрд холбогдох хэсгийг, Баттулга овогтой Одончимэг, Нагоя их сургууль, График дизайн 4 жил, 2015 оны А/155 дугаар тушаалын хавсралтын "24. Алтангэрэл овогтой Анарт холбогдох хэсгийг Нэргүй овогтой Ариун-Эрдэнэ, Калифорны их сургууль, Лос Анжелес, Бизнесийн удирдлага, 3 жил" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2016 оны А/215 дугаар тушаалын хавсралтын "12. Эрдэнэбат овогтой Маралмаад холбогдох хэсгийг Болдбаяр овогтой Мэргэн, Манчестерийн их сургууль, Байгаль орчны менежмент, 4 жил" гэж, "40. Жүгдэрхүү овогтой Булганд холбогдох хэсгийг Гантөмөр овогтой Төгөлдөр, Бристолын их сургууль, Нийгмийн ухаан, 4 жил" гэж, "76. Эрлонбауржан овогтой Жангүлд холбогдох хэсгийг Лхагвасүрэн овогтой Сарнай, Сидней их сургууль, Бизнесийн удирдлага 4 жил, гэж тус тус өөрчилсүгэй.
2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /М.Мөнхбаатар/ нарт тус тус даалгасугай.

САЙД

Ж.БАТСУУРЬ



9 0771